



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 26 одор

Дугаар 7/03

Эрдэнэт

Г Санхүүгийн аудитын дүнтэй холбогдуулан  
авах зарим арга хэмжээний тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дахь заалт, аймгийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудит, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудит, орон нутгийн хөгжлийн сангийн нийцлийн аудитын дүнгийн тухай Орхон аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандахын илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аудитын дүнгээр хүргүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, дүнг III улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг Орхон аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор /Ц.Нармандах/-т даалгасугай.

Хоёр:Аймгийн Засаг дарга Д.Батлутад ДААЛГАХ нь:

2.1.Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэн, төсвийн орлого бүрдүүлэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, орон нутгийн төсвийг хэмнэлттэй үр дүнтэй зарцуулах, судалгаа тооцоолол хийн төлөвлөж, төсвийн сахилга батыг хангуулах.

2.2.Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын анхан шатны баримтын бүрдүүлэлт, бүртгэл хөтлөлтөд анхаарч, төсвийн шууд захирагч, нягтлан бодогчдын мэдлэг үр чадварыг дээшлүүлэх, бараа материал, авлага, өр төлбөрийн үлдэгдлийн өсөлтөд судалгаа хийх, үлдэгдлийг бууруулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, төсвийг бодитой төлөвлөх.

2.3.Аймгийн Засаг даргын нөөц, хуваарилагдаагүй бусад хөрөнгийн зарцуулалттай холбоотой ТББ, иргэнтэй байгуулсан гэрээгээр түүний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан, орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгжүүд алдагдалтай ажиллаж байгаад анхаарч хууль журамд нийцүүлэх.

2.4.Улс, орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудыг холбогдох хууль журамд нийцүүлэн төлөвлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, зураг төсөвт хяналт тавих чиг үүргийг тодорхой болгох.

2.5.Аудитын дүнгээр хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах.

ДАРГА П.ПУРЭВЛХАГВА

C:\Togtool \A4 doc

00100145